

2021 оны жилийн тайлан

“ЛэндМН ББСБ” ХК —————



Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан

• Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	04	Мэндчилгээ
• Компанийн тухай	08	Компанийн тухай
	09	2021 оны онцлох үйл явдлууд
	12	Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
• Бизнесийн үйл ажиллагаа	14	2021 оны гол үзүүлэлтүүд
	16	Зээлийн үйл ажиллагаа
	20	Харилцагчийн үйлчилгээ
	21	Хүний нөөц
• Санхүүгийн үйл ажиллагаа	22	2021 оны гол үзүүлэлтүүд
	23	Санхүүгийн байдлын хураангуй тайлан
	24	Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
• Эрсдэлийн удирдлага	26	Эрсдэлийн удирдлага
	28	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
• Компанийн засаглал	29	Компанийн засаглал
	30	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
	36	Компанийн бүтэц, зохион байгуулалт
	38	Хувьцааны мэдээлэл
	39	Ногдол ашгийн мэдээлэл
	41	“Лэнд Бонд”-ын мэдээлэл

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Зээлийн болон хөрөнгө оруулалтын
бүтээгдэхүүнүүдээ нэмж үйл ажиллагаагаа тэлнэ



Сайн байна уу?

Эрхэм Лэндчүүд, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, бизнесийн түнш, хамтрагч байгууллагууд, бидэнд үргэлж итгэл хүлээлгэн үргэлж дэмжин ажилладаг нийт харилцагчид болон Монгол улсынхаа хөгжлийн төлөө өдөр бүр зогсолтгүй ажиллаж байгаа эрхэм бизнес эрхлэгч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

“ЛэндМН ББСБ” ХК нь (Ковид-19) цар тахалтай холбоотойгоор шинээр хэрэгжиж буй Монгол Улсын хууль, Засгийн Газрын тогтоол, шийдвэрүүдийг мөн зохицуулагч байгууллагаас гаргасан мэдэгдэл, журмыг үйл ажиллагаандаа цаг алдалгүй чандлан мөрдөж ажилласан төдийгүй, нийгэм эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдалд оновчтой шийдвэрийг тухай бүр гаргаж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, харилцагч нартаа уян хатан, боломжит нөхцөлийг санал болгох, системийн шинэчлэлтийг хийж, шинэ бүтээгдэхүүн гаргах дэд бүтцийг бий болгох, бизнесийг өсөлтийг хангах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллалаа.

2021 онд компани маань 4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, зорилтот түвшинд хүрсэн тул Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 оны 02 сарын 07-ны өдрийн ээлжит хурлаараа нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол

ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэлээ. Энэ нь ковидын өмнөх үе буюу 2019 оны нэгж хувьцааны ногдол ашгийн дүн болох 1.5 төгрөгөөр хуваарилсантай адил байгаагаар онцлог юм.

Бид өөрсдийн хувьцааны (MSE: LEND) хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, Хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах үүднээс олон улсад нийтлэг хэрэгжүүлдэг хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг 2 дахь удаагаа зарлаж, ТУЗ-ийн 21/17 тоот тогтоолын хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хаалтын байдлаар нийт 19,088,587 ширхэг хувьцааг халаасалсан байна.

Өнгөрөгч 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар 1 сая ам.доллар буюу 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 5 жилийн хугацаатай, 14% хүүтэй хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шийдвэр гарч Санхүүгийн зохицуулах хорооноос зохих зөвшөөрлийг авсны үндсэн дээр ЛэндМН компани маань өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлээ.

Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” уриатай нээлттэй бондыг 2 дахь жилдээ амжилттай гаргаж, 2021 оны 6 дугаар сарын 25-наас 30-ны өдрийн хооронд нийт 505 хөрөнгө оруулагчдаас 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татлаа. Нийт 7,583,500,000 төгрөгийн захиалга хүлээн авсан нь “ЛэндБонд” маань Дижитал ►►

хөрөнгө оруулалтын брэнд болж эрэлт өндөртэй байсныг харуулж байна. 2021 оны 11 дүгээр сарын 29-нд “ЛэндБонд-3”-ыг 4 удаагийн транчаар буюу хэсэгчилсэн байдлаар хөтөлбөртэйгөөр зарлан хэрэгжүүлж байгаа бөгөөд LendMN аппликэйшнээр дамжуулан анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлж “ЛэндБонд” Транч I-ээр нийт 44-н хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлээ.

Нийгмийн хариуцлагын хүрээнд харилцагч нарынхаа санхүүгийн байдалд учирч болох эрсдэлийг хамтдаа даван туулах, шийдвэрлэх зорилгоор зээлээ хугацаандаа эргэн төлөхөд хүндрэл учирсан харилцагчийн зээлийн үндсэн төлбөрийн 10%-ийг (хамгийн багадаа) шимтгэлийн хамт төлж зээлээ хэдэн ч удаа сунгах боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Өнөөгийн өсөн нэмэгдэж, хурдтай хөгжиж буй крипто арилжаанд оролцогчдын хувьд өөр хоорондоо крипто арилжаалах хүсэлт үүсгэж, төлбөрийн асуудлаа LendMN-ээр хялбархан шийдэж төгрөгөөр

гүйлгээ хийх боломж бүрдлээ. Дэлхийн №1 crypto to exchange Binance дээр LendMN P2P төлбөрийн хэрэгслээр нэмэгдсэн сайхан мэдээг харилцагч нартаа дуулгахад таатай байна.

ЛэндМН нь өөрсдийн найдвартай, үнэнч харилцагч нартаа байгаль орчинд ээлтэй, хагас цахилгаан мотортой машинуудыг зээлээр авах боломжийг олголоо. Энэхүү эко автомашины зээлийн бүтээгдэхүүнийг улам боловсронгуй болгохоор зорин ажиллаж байна.

Цар тахлын үед хэрэглэгч нартаа зайнаас авах боломжтой хөрөнгө оруулалтын цоо шинэ бүтээгдэхүүн болох “Plus” итгэлцлийн үйлчилгээг SuperUp аппликэйшнээр дамжуулан амжилттай нэвтрүүлээ.

Монгол орон даяар цахим зээлийн гэрээ байгуулах аяныг явуулж, LendMN аппликэйшнээр дамжуулан Улаанбаатар хот төдийгүй алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн үйлчилгээ авах боломжийг олголоо.

Дэлхий даяар байгаль орчны өөрчлөлтөд анхаарал хандуулж буй энэ үед ЛэндМН нь ногоон санхүүжилтийг дэмжих, Монгол Улсын хэмжээнд тулгараад буй байгаль орчны хор нөлөөг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулах, энэхүү



Харилцагчдадаа шинэ бүтээгдэхүүнээр бэлэг барина.

үйл хэрэгт Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудыг манлайлан ажиллах зорилгоор Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС холбоо)-ны гишүүнээр элсэн орсон. Бид зорилгынхоо хүрээнд компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг байгальд ээлтэй байх зарчмыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Тогтвортой санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх хариуцлагатай аялалд мөр зэрэгцэн алхах болсондоо ЛэндМН-ийн хамт олон баяртай

байна.

Бид бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, дэлхийд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, байгуулмагын нийт хамт олон хамтдаа өсөндэвжиж, тасралтгүй хөгжих тал дээр анхааран ажиллаж байгаа билээ. ЛэндМН-ийн үндсэн систем болон аппликэйшнийг Анд группийн охин компани хөгжүүлдэг. Энэ жил группийн охин компани болох “Анд Солюшин” компанитай технологи нийлүүлэх болон лицензийн гэрээ үзэглэлээ. Тодруулбал тус гэрээгээр үндсэн систем нийлүүлэх, сайжруулах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх нөхцөлүүдээ шинэчлэн баталсан юм. Тийм ч утгаараа зээлийн болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдээ нэмж үйл ажиллагаагаа тэлэх боломжтой болж байна. LendMN-ийн зээлийн эрхтэй харилцагч ЛэндМН-тэй хамтрагч байгууллагуудаас хүссэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ урьдчилгаагүй Шууд аваад, хүү шимтгэлгүй Хувааж төлөөд, төлөлт бүртээ Бонус оноо хүлээн авах нөхцөлтэй үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Бидэнд үргэлж итгэл хүлээлгэж, дэмжин ажилладаг нийт харилцагчид, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартаа ЭРҮҮЛ ЭНХ, амжилт, аз жаргалыг хүсье. Ингээд та бүхэндээ 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна. ■



Хүндэтгэсэн: “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Угвал

Компанийн тухай



Үнэт зүйлс

Инноваци, хурд, хариуцлага, мэргэшсэн өндөр чадвар, зогсолтгүй суралцах зарчим, хүн төвт зарчим



Алсын хараа

Дэлхийн энтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ Монголын санхүүгийн зах зээлд манлайлна.



Эрхэм зорилго

Хиймэл оюун ухаанд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ санхүүгийн салбарт шинэ жишиг тогтоогч таны АНД байна.

2021 оны онцлох үйл явдлууд

01 сар



Хувьцаагаа эргүүлэн худалдан авах хоёр дахь хөтөлбөрийг зарлалаа.

Компанийн зүгээс өөрийн хувьцааны худалдан авалтыг дэмжсэнээр хувьцааны хөрвөх чадвар нэмэгдэн, компанийн үнэлгээ хэт доогуур үнэлэгдэхээс сэргийлэхээс гадна хувьцаа эзэмшигч нарынхаа хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах чухал ач холбогдолтой шийдвэр хэмээн үзсэн юм.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдсан бөгөөд компанийн өөрийн гаргасан хувьцааны ханшийг тогтворжуулах зорилгоор хувьцааг үргэлжлүүлэн худалдаж авах шийдвэрийг дахин гаргаж ТУЗ-ийн 21/17 тоот тогтоолоор баталлаа.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хаалтын байдлаар 21/17 тоот тогтоолын хүрээнд нийт 19,088,587 ширхэг хувьцаа халаасалсан байна.

Харилцагч нартаа зээлийн эргэн төлөлтийн таатай нөхцөлийг үргэлжлүүлэн санал болголоо.

Хөл хорионы улмаас харилцагч зээлээ хугацаандаа эргэн төлөхөд хүндрэл учирсан бол тухайн зээлийн үндсэн төлбөрийн 10%-ийг (хамгийн багадаа) шимтгэлийн хамт төлж зээлээ хэдэн ч удаа сунгах боломжийг бүрдүүлсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд харилцагч нарынхаа санхүүгийн байдалд учирч болох эрсдэлийг хамтдаа шийдвэрлэх зорилгоор тухайн цаг үеийн шийдвэрүүдэд тохируулан түргэн шуурхай ажиллалаа.

02 сар



Ногдол ашгаа хуваариллаа.

Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу компанийн 2020 оны цэвэр ашгийн 20% буюу нийт 442,246,365.72 төгрөгийг хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг болгон хуваариллаа.



2021 оны онцлох үйл явдлууд

03 сар

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2 дахь жилдээ амжилттай боллоо.

Хоёр дахь удаагаа цахим хэлбэрээр хийгдэж буй энэхүү хурал нийт хувьцаа эзэмшигч нарт эрсдэл учруулахгүйгээр, халдвар хамгаалмын дэглэмийг чанд баримтлан зохион байгуулагдлаа. Хурлыг компанийн фэйсбүүк пэйж хуудсаар шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд энэхүү хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.59% нь оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэн баталлаа.

04 сар

Дэлхийн №1 crypto exchange Binance дээр LendMN P2P төлбөрийн хэрэгслээр нэмэгдлээ.

Монголын хэрэглэгчид Binance P2P дээр LendMN-ийг ашиглан төгрөгийн гүйлгээ хийж, крипто худалдаж авах, борлуулах боломжтой боллоо. Өнөөгийн өсөн нэмэгдэж, хурдтай хөгжиж буй крипто арилжаанд оролцогчдын хувьд өөр хоорондоо крипто арилжаалах хүсэлт үүсгэж, төлбөрийн асуудлаа LendMN-ээр хялбархан шийдэж төгрөгөөр гүйлгээ хийх боломж бүрдлээ.

05 сар

Plus итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлээ.

Цар тахлын үед хэрэглэгч нартаа зайнаас авах боломжтой хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн болох санхүүгээ зөв удирддаг хүн бүрт зориулсан богино хугацааны “Plus итгэлцлийн”-үйлчилгээг SuperUp аппликейшнд амжилттай нэвтрүүлээ.

1 plus нь 7, 14, 21, 28 хоногийн хугацаатай, хамгийн багадаа 100,000 төгрөг, хамгийн ихдээ 1 сая төгрөг хүртэл итгэлцэл байршуулна.

06 сар

Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд”-ыг 2 дахь жилдээ амжилттай гаргалаа.

Монголын финтек салбарын тэргүүлэгч компани болох “ЛэндМН ББСБ” ХК нь 2021 оны 6 дугаар сарын 25-наас 30-ны өдрийн хооронд олон нийтээс нээлттэйгээр захиалга авсан бөгөөд нийт 505 хөрөнгө оруулагчдаас 7,583,500,000 төгрөгийн захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 51.7%-иар давж биеллээ.

07 сар

Эко автомашины зээлийн үйлчилгээг нэвтрүүлээ.

Бид үнэнч харилцагч нартаа зориулан байгаль орчинд ээлтэй, хагас цахилгаан мотортой эко машин болох Prius30, Prius40, Prius 41, Toyota Aqua автомашинуудыг хиймэл оюун ухаанд суурилан харилцагчийн скоринг хийж онцгой нөхцөлтэйгээр санал болгож нэвтрүүлээ.



08 сар

Thunes-Гадаадаас мөнгөн гуйвуулга хүлээн авах үйлчилгээг нэвтрүүлээд хэдийнээ 2 жил болжээ.

Thunes компани нь дэлхийн 126 гаруй орны 9000 гаруй компанийн төлбөрийн системтэй хамтран ажилладаг. Хамтын ажиллагааны хүрээнд Western Union болон БНСУ-ын Napass төлбөрийн системээр дамжуулан Монгол Улс руу LendMN-ийн хэрэглэгч нарт хамгийн хурднаар, хамгийн бага шимтгэлтэйгээр мөнгөн гуйвуулга хүлээн авах боломжийг олгодог. Хүлээн авагч нь LendMN аппликейшний хэрэглэгч байх ба өөрийн бүртгэлээ баталгаажуулснаар гадаад гуйвуулгыг хялбархан хүлээн авах боломжтой.



09 сар

Монгол орон даяар цахим зээлийн гэрээ байгуулж эхэллээ.

ЛэндМН-ийн зүгээс хөдөө орон нутгийн харилцагч нартаа цахим зээлийн гэрээ байгуулах “Зон Олондоо Зориулыа” компани ажлыг зохион байгуулж, тухайн орон нутагтаа санхүүгийн асуудлаа шийдэх боломжийг олгож ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд Монгол орон даяар цахим зээлийн гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд 21 аймаг, 9 дүүрэгт гэрээ байгуулах боломжтой боллоо.

Монгол улсын Тогтвортой санхүүгийн холбоонд нэгдлээ.

ЛэндМН нь тогтвортой санхүүгийн зарчим, стандарт хэрэгжүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, чадавх бэхжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд хамтран ажиллах зорилгоор ToC Холбоо / MSFA-нд Үндсэн гишүүнээр нэгдлээ.

12 сар

Нийт харилцагч нартаа “Лэндтэй Шинэ жил” урамшууллыг зарлалаа.

LendMN аппликейшнээр зээлээ аваад азтан болох боломжтой “Лэндтэй Шинэ жил” урамшууллыг зарлаж, 3 удаагийн фэйсбүүк лайв хийж азтануудыг тодруулж нийт 21 азтанд Tous Les Jours 50,000₮-ийн бэлгийн карт, Супер 3 азтанд “Airpods Pro”, “Galaxy Watch Active 2 black”, “Iphone 13”-ийг тус тус бэлэглэлээ.

11 сар

Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд 3” транч 1 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр “ЛэндБонд 3”-ыг 4 удаагийн транчаар буюу хэсэгчилсэн байдлаар бонд гаргах хөтөлбөртэйгөөр хэрэгжүүлж “Лэнд Бонд” Транч 1-ийг олон нийтэд санал болгож 2,500,000,000 төгрөгийг арилжааны эхний өдөр нийт 44 хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлээ.

Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө

Нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа 3 цаг зарцуудаг гэж үзвэл бид онлайнар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр 182 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 547 мянган цаг буюу 62 жилтэй тэнцэх хугацааг хэмнэх боломжийг олгожээ.

62
жил

Хэрэглэгчдэд хэтэвчийн үйлчилгээг шимтгэлгүй үзүүлснээр нийт 263 сая төгрөгийн банкны шимтгэлийн зардлыг хэмнэжээ.

263
сая төгрөг

Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуудаг. Бид 861 мянган удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 64.6 тонн цаас хэмнэж 1550 ширхэг мод аварчээ.

1550
мод

Компанийн хөрөнгө оруулагчдад нийт 2.7 тэрбум төгрөгийн хүү төлсөн байна.

2.7
тэрбум төгрөг

Барьцаагүй зээлийн үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдийн 192.3 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах үйлдлээс сэргийлж, барьцаа хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.

192.3
тэрбум төгрөг

Аж ахуй нэгжийн орлогын албан татварт 470 сая төгрөгийг төлсөн байна.

470
сая төгрөг

Нийгмийн даатгалын шимтгэлд байгуулагаас 262.5 сая, ажилтнуудаас 182.2 сая төгрөгийг төлжээ.

444.7
сая төгрөг

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хатуу хөл хорио тогтоосон үед ажлын байрыг 100% хэвээр хадгалж, цалин хөлсийг хугацаанд нь тогтмол олгож ажиллалаа. Бид шинээр бүтэн цагийн 6 ажлын байр бий болгон, нийт цалин урамшуулал, хангамж болон тэтгэмжид 2.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

100%
ажлын байр

Гуравдагч этгээдээс авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт:

- Худалдан авалт болон хамтын ажиллагаа 1.9 тэрбум төгрөг
- Хандив тусламж 24.5 сая төгрөг

1.9
тэрбум төгрөг




Бизнесийн үйл ажиллагаа

2021 оны гол үзүүлэлтүүд


Бүртгүүлсэн хэрэглэгч

11%



Зээлийн харилцагч


4%



Олгосон зээлийн тоо

867

мянган удаа




2021

Олгосон зээлийн хэмжээ

183.4

тэрбум төгрөг



2021




Бизнесийн үйл ажиллагаа

Зээлийн үйл ажиллагаа




2021 онд гэрээт харилцагчдын тоо өмнөх жилээс 4%-иар өсч, 182.5 мянгад хүрлээ. Мөн энэ онд нийт 183.4 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 867 мянган зээлийг харилцагч


нартаа олгож, цэвэр зээлийн багц 32.4 тэрбумд хүрлээ. 120.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 767 мянган харилцагчдын зээлийг сунгаж ажиллалаа.




Хүйсийн харьцаа



Насны ангиллаар



Зээлийн үйл ажиллагаа



Бизнесийн үйл ажиллагаа

Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 27 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2021 оны турш нийт 266,807 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 98.85%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн

шийдвэрлэсэн байна.

Улсын онцгой комиссоос гаргасан хөл хорио дэглэмийг чанд баримтлан үйлчилгээний заал ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, цахим хэлбэрээр болон 09:00- 20:00 цагийн хооронд хуваарийн дагуу харилцагчийн үйлчилгээг цаг алдалгүй, тасралтгүй хүргэж байна.



Харилцагчийн үйлчилгээ

2021 онд хүлээн авсан

266,807

Нийт дуудлага

15 секунд

Хүлээлгийн түвшин

Үйлчилгээ

98.85%

амжилттай хүргэсэн

сошиал суваг болон

61,062

үйлчилгээний заалаар үйлчилсэн

Хүний нөөц

Компанийн нийт ажилтнуудын тоо

98

Үндсэн ажилтан

78
20

Гэрээт болон цагийн ажилтан

Дундаж нас

29.7



35.7%
Эрэгтэй

64.3%
Эмэгтэй

Санхүүгийн үйл ажиллагаа

2021 оны гол үзүүлэлтүүд

Нийт актив

39.3

тэрбум төгрөг

Нийт орлого

12.5

тэрбум төгрөг

Цэвэр ашиг

4.0

тэрбум төгрөг

Зээлийн багц

32.4

тэрбум төгрөг

Санхүүгийн байдлын хураангуй тайлан /Аудитлагдсан/

2021 оны эцсийн байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 39.3 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 32.4 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 4.9 тэрбум

төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 19.5 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 19.8 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 11.3 тэрбум төгрөг байна.


Санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2019	2020 /нэгтгэсэн/	2021 /нэгтгэсэн/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	2.38	10.35	4.90
Зээлийн багц (цэврээр)	49.46	25.43	32.43
Бусад хөрөнгө	4.75	3.44	0.77
Үндсэн хөрөнгө	1.16	1.11	0.76
Биет бус хөрөнгө	0.34	0.40	0.45
Нийт хөрөнгө	58.10	40.73	39.31

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2019	2020 /нэгтгэсэн/	2021 /нэгтгэсэн/
Өр төлбөр	40.90	23.02	19.49
Эх үүсвэр	38.57	21.11	15.07
Хоёрдогч өглөг	-	-	2.95
Бусад өглөг	2.32	1.91	1.47
Эздийн өмчийн дүн	17.2	17.71	19.81
Хувьцаат капитал	10.55	9.82	8.48
Хуримтлагдсан ашиг	6.65	7.89	11.33
Нийт өр төлбөр болон эздийн өмч	58.10	40.73	39.31




Нийт актив, пассив
/тэрбум төгрөг/



Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж /хувь/



Орлого болон Цэвэр ашиг /тэрбум төгрөг/



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдсан/

2021 оны эцсийн байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 12.5 тэрбум төгрөгт хүрч, нийт 4 тэрбум төгрөгийн үндсэн үйл ажиллагааны цэвэр ашигтай ажилласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2019	2020 /нэгтгэсэн/	2021 /нэгтгэсэн/
Нийт орлого	18.32	16.37	12.49
Хүүгийн зардал	(4.65)	(4.72)	(2.80)
Цэвэр орлого	13.66	11.65	9.69
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(1.62)	(2.36)	0.73
Үйл ажиллагааны цэвэр орлого	12.04	9.29	10.42
Удирдлагын болон ҮА-ны зардал	(6.02)	(6.54)	(5.95)
Татварын өмнөх ашиг	6.02	2.75	4.47
Татварын зардал	(1.12)	(0.32)	(0.47)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг	4.91	2.43	4.00
Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)	-	-	(0.11)
Цэвэр ашиг	4.91	2.43	3.89

Эрсдэлийн удирдлага



“ЛэндМН ББСБ” ХК нь Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгож, бэхжүүлэхийн тулд Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу “Гурван шатлалт хамгаалалт”-ыг бүрдүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэм, хэмжээг тодорхойлсон нь компанийн бизнесийн стратеги төлөвлөгөөтэй нийцүүлэн, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа нь компанийн найдвартай байдлыг нэмэгдүүлж байна. Нөгөөтэйгүүр эрсдэлийг зохистой хэмжээнд удирдах, эдийн засаг, зохицуулалтын орчин, өрсөлдөөн дэх хөгжил, хариу үйлдэл, өөрчлөлтөд бэлэн байх

зэрэг төлөвлөгөөг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг.

“ЛэндМН ББСБ” ХК нь COVID-19 цар тахалтай холбоотойгоор шинээр хэрэгжиж буй Монгол Улсын хууль, Засгийн Газрын тогтоол, шийдвэрүүдийг төдийгүй зохицуулагч байгууллагаас гаргасан мэдэгдэл, журмыг үйл ажиллагаандаа цаг алдалгүй чандлан мөрдөж ажилласан төдийгүй харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг цаг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажиллаа.

Нөгөөтэйгүүр цар тахалаас үүдэлтэй тодорхойгүй нөхцөл байдалд ажиллах, оновчтой менежментийг хэрэгжүүлэх, урьдчилан таамаглах, хариу арга

хэмжээ авах зэрэг нь эрсдэлийн удирдлагын тогтолцоонд шинэ дэвшлийг авчирч, цаашдын компанийн стратегийн хөгжилд нөлөөлөхүйц түлхэц болмоо гэж үзэж байна. Улсын хэмжээнд Ковид-19 халдварын тархалт улам нэмэгдэж, өдөрт мянга мянгаар шинэ тохиолдол бүртгэгдэж байсан эрсдэлтэй цаг үед ажилтнуудынхаа эрүүл

мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс онлайн хэлбэрт шилжүүлж гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Онцгой байдлын үед ажиллах журам” болон “Ковид-19 үеэр ажиллах заавар”-ыг тус тус боловсруулж, батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллалаа. Энэ нь онцгой эсвэл эрсдэлтэй нөхцөл байдалд компанийн үйл ажиллагаа тасралтгүй найдвартай хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Нөгөөтэйгүүр цахимаар бүтээмжтэй ажиллах хэв маягт суралцаж, өөрчлөлтөд дасан зохицох, мэдээллийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг оновчтой удирдах боломж бүрдсэн гэж үзэж байгаа билээ.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Эрсдэлийн удирдлагын бодлого, Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого, Эх үүсвэрийн төлөвлөгөө, Зээл түүнтэй адилтгах, активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогын хэрэгжилтийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын хороо хэлэлцэн дүгнэдэг.

Тус хороо нь 2021 оны 02 сарын 05 өдөр Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах компанийн тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлого”-ыг хэлэлцэн ТУЗ-ийн 21/02 тогтоолоор батлалсан төдийгүй 2021 оны 12 сарын 23 өдрийн ТУЗ-ийн 21/45 тоот тогтоолоор “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг, 21/46 тоот тогтоолоор “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-ыг тус тус нэмэлт өөрчлөлт орж, шинэчлэн баталсан билээ.

Түүнчлэн эрсдэлийн удирдлагын бодлогод суурилж компанийн үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэй удирдах, хянах, учирч болзошгүй үйл ажиллагааны эрсдэлүүдийг тодорхойлон, тэдгээрт хариу арга хэмжээ авах, бууруулах зорилгоор “Үйл ажиллагааны эрсдэлийн журам”-ыг, Ёс зүйн хэм хэмжээний зөрчлийг мэдээлэх, шударгаар шийдвэрлэх, ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Шүгэл үлээх журам”-ыг тус тус Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж өдөр тутмын үйл ►►

ажилгаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. “ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2021 оны жилийн эцэст 1.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 2.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь

Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 125%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2021 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2019	2020	2021
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	26.00%	52.1%	48.6%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	26.01%	52.1%	55.5%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	29.6%	46%	50.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	17.8%	43.2%	29.4%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-5.3%	0.5%	-11.09%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	79.7%	55.2%	33.5%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	20.5%	38.7%	32.3%

Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Монгол Улсын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болохынхоо хувьд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус гаргадаг засаглалын дүрэм, журам, кодексыг дагаж мөрдөн ажилладаг билээ. “ЛэндМН ББСБ” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл санхүү, хөрөнгийн зах зээлд шинийг санаачлагч, манлайлагч байсаар ирсэн уламжлалаа хадгалж компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилгоор COVID-19 цар тахал дэгдсэн нөхцөл байдалд уялдуулан хувьцаат компаниудыг манлайлж 2021 онуудад Хувьцаа эзэмшигчдийн хурлаа “Цахим хэлбэр”-ээр дахин амжилттай зохион байгуулсан билээ.

Тус ХЭХ-аар жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох, хараат бус гишүүнийг сонгох, ТУЗ-ийн төсвийг батлах, компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах зэрэг олон чухал асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн билээ.

Компани нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийг улирал бүр олон нийтэд тайлагнан, ХЭХ болон ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрийг тухай бүр нээлттэй мэдээлэн ажиллаж байна.



Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн дарга

О.Болдбаатар

ЭУХ-ны гишүүн
“АНД Глобал” ПиТиИ
ЭлТиДи-ийн Захирал

ТУЗ-ийн гишүүн

Ц.Одмаа

Аудитын хорооны гишүүн
“Ай Эн Мобайл Нэтворк”
ХХК-ийн Хууль, Хянан
нийцүүлэлт хариуцсан
захирал

ТУЗ-ийн гишүүн

В.Баярсайхан

ЭУХ-ны гишүүн
“Томъёо Эд Тек” ХХК-ийн
Ерөнхий Захирал

ТУЗ-ийн гишүүн

С.Энх-Амгалан

ЗНДЦУХ-ны Дарга,
ЭУХ-ны гишүүн
“Мэргэн инвестмент”
Пти.Лтд-ийн Захирал

ТУЗ-ийн гишүүн


Б.Дэлгэржаргал

ЭУХ-ны Дарга

ТУЗ-ийн гишүүн

Н.Цэвэгмид

ЭУХ-ны гишүүн,
“Райнос Инвестмент
ҮЦК” ХХК-ийн Хөрөнгө
оруулалт хариуцсан Захирал,
МҮЦАЭХ-ны ҮЗ-ийн гишүүн



Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Д.Галхүү

ЭУХ-ны гишүүн,
ЗНДЦУХ-ны гишүүн,
“ПрайсвотерхаусКуперс Аудит” ХХК-ийн Аудитор

ТУЗ-ийн хараат бус гишүүн

С.Боргил

Аудитын хорооны гишүүн,
ЗНДЦУХ-ны гишүүн
“Сэргэлт Консалтинг групп”-ийн Гүйцэтгэх Захирал

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ж.Жаргалсүрэн

Аудитын хорооны Дарга,
“Далайван Аудит” ХХК-ийн Гүйцэтгэх Захирал



Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой төвшинд удирдах, стратегийн зорилтдоо хүрэхэд нь Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

ТУЗ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшуулмын хороодтой.


2021 оны 3 дугаар сард ХЭХ-аар томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ. ТУЗ-ийн хараат бус гишүүн Болдын Өлзийбаяр 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсний дагуу ТУЗ тухайн гишүүний хүсэлтийг хүлээн авч, 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр хараат ТУЗ-ийн бус гишүүнээс чөлөөлсөн. ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшуулмын

хорооны дүгнэлтийг үндэслэн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит бус хурлаар Монгол Улсын иргэн, “ПрайсвотерхаусКуперс Аудит” ХХК-ийн Аудитор Даваасамбуу овогтой Галхүүг ХЭХ хуралдах хүртэл хугацаанд ТУЗ-ийн хараат бус түр гишүүнээр томилоод байна.

ТУЗ тогтмол хуралдаж, холбогдох тогтоол шийдвэрийг гарган ажиллаж байгаа ба өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 7 удаа ээлжит бусаар хуралдаж, нийт 46 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 5 удаа, Эрсдэлийн удирдлагын хороо 5 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшуулмын хороо 3 удаа тус тус хуралдсан байна.

ТУЗ-өөс Компанийн үйл ажиллагааг зөв зохистой удирдахад чиглэсэн бодлогын бичиг баримтуудыг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах чиг үүргийнхээ хүрээнд Компанийн Бизнес төлөвлөгөө болон Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг баталсан төдийгүй Эрсдэлийн удирдлагын бодлого, Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогод тус тус нэмэлт өөрчлөлт орж, шинэчлэн баталсан билээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал



Эрх бүхий албан тушаалтнууд



Б.Удвал

Гүйцэтгэх
Захирал



М.Түвшинжаргал

Санхүү, үйл ажиллагааны
газрын Захирал



М.Бямбасүрэн

Эрсдэлийн удирдлагын газрын
Захирал




Г.Золжаргал

Ерөнхий
нягтлан бодогч

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Дотоод зохицуулалт
/Компанийн дүрэм, журам, удирдамж, үнэт зүйл/

Гадаад зохицуулалт
/Хууль эрх зүйн зохицуулалт, Зохицуулагч байгууллагын дүрэм, журам, Кодекс/




Хувьцааны мэдээлэл

2021 оны 1 сарын 1-нээс 2021 оны 12 сарын 31 хүртэлх хугацаанд хувьцааны ханш 26% өссөн.

IPO хийснээс хойш нийт 286,866,034 ширхэг, 14.3 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан.


Нэгж хувьцаанд ногдох ашиг (Төгрөг)



2021 онд нийт арилжаалагдсан ширхэг (Сая ширхэг)



2021 онд нийт арилжаалагдсан үнийн дүн (Тэрбум төгрөг)



Ногдол ашгийн мэдээлэл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 21/05 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 0.58 төгрөг буюу нийт 442,246,365.72 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлсэн билээ.

“ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгийн зах зээлийн амин хөдөлгүүр болох хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс Олон улсад нийтлэг авч хэрэгжүүлдэг хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг боловсруулан, 2021 онд дахин хэрэгжүүлсэн билээ. Үүний үр дүнд 2021 онд компанийн хувьцааны ханшийг тогтворжуулж, хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг хамгаалсаар байна.


2021 онд:

Нийт арилжаалагдсан ширхэг - 57.25 сая ширхэг


Нийт арилжаалагдсан үнийн дүн - 2.48 тэрбум төгрөг

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 04 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын 21/17 тоот тогтоолын дагуу “ЛэндМН ББСБ” ХК нь 2021 оны 04 сарын 23-ны өдрөөс эхлэн МХБ-ээс өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авах боломжтой болсон бөгөөд 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 19,088,587 хувьцааг худалдан авч халаасалмаа.

Хувьцааны ханш




Хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувь



“ЛэндБонд”-ын мэдээлэл

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын финтек салбарын нээлттэй “ЛэндБонд”-ыг хөрөнгийн зах зээлд 2 дахь удаа амжилттай гаргалаа. Бид дэлхийн эдийн засаг хумигдаж улс орнуудад эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн

боллоо. Хөрөнгийн зах зээлд 2 дахь жилдээ 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “ЛэндБонд”-ын анхдагч зах зээлийн арилжаа 2021 оны 6 дугаар сарын 25-наас 29-ний өдрийн хооронд 5 хоногийн хугацаанд үргэлжилсэн бөгөөд нийт



энэ үед Монголын финтек салбарын нээлттэй “ЛэндБонд”-ыг жилийн 14%-ийн хүүтэй, 2 жилийн хугацаатай Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж олон нийтээс 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээ. “ЛэндБонд”-ын андеррайтераар “Өлзий энд Ко Капитал” ҮЦК ХХК ажиллаж “Райнос Инвестмент” ҮЦК ХХК синдикатаар ажиглалаа. “ЛэндБонд”-ын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг Үнэт цаасны компаниудаар дамжуулан авахаас гадна SuperUp аппликэйшнээр захиалга өгөх боломжтойгоор зохион байгуулсан нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд нэгэн шинэ алхам

505 хөрөнгө оруулагчдаас 7.5 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авснаар анхдагч зах зээлийн захиалга 51.7%-иар давж биелсэн ба хоёрдогч зах зээлийн арилжаагаар 138 сая төгрөгийн үнийн дүн бүхий 1.3 мянган ширхэг бонд арилжагдсан байна. Мөн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “ЛэндБонд”-ын I транчийн захиалга явагдаж нийт 44 хөрөнгө оруулагчаас 2.5 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авснаар анхдагч зах зээлийн захиалга 100%-тай биелсэн бөгөөд 2022 оны эхний улиралд “ЛэндБонд”-ын хөтөлбөрийн хүрээнд 3.1 тэрбум төгрөгийн “ЛэндБонд”-ыг олон нийтэд санал болгохоор төлөвлөж байна.



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn